



МОНГОЛ УЛСЫН СОЁЛ, СПОРТ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
САЙДЫН ТУШААЛ

до 25 оны 01 сарын 31 онд

Дугаар A/23

Улаанбаатар хот

Г Шалгуур үзүүлэлт, ажлын хэсгийн
бүрэлдэхүүн батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дугаар зүйлийн 2 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.5 дахь заалт, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний шигшээ багийн чиг үүргийг хэрэгжүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт”-ийг нэгдүгээр, “Үндэсний шигшээ багийн чиг үүргийг хэрэгжүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар ёсоор тус тус баталсугай.
2. Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу Үндэсний шигшээ багийн чиг үүргийг хэрэгжүүлэх спортын холбоог сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хороо (О.Баттулга)-нд даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Даваажаргал)-д үүрэг болгосугай.



14190010952

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын
сайдын 2025 оны 01 дугээр сарын
31-ны өдрийн 02 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
СПОРТЫН ХОЛБООГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

ATA12931 6594208 9024070543

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үндэсний шигшээ баг нь олон улсын олимпын хороо, олон улсын паралимпын хорооны ивээл дор зохион байгуулагддаг олимпын эрх олгох, оноо цуглуулах, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадамд Монгол Улсыг төлөөлж оролцоно.

1.2. Улсын төсөв болон спортыг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх үндэсний шигшээ багийн чиг үүргийг хэрэгжүүлэх спортын холбоог сонгох, үндэсний шигшээ багийг бүрдүүлэх тамирчин, дасгалжуулагчийг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцаанд энэхүү шалгуур үзүүлэлтийг удирдлага болгоно.

**ХОЁР. СПОРТЫН ХОЛБОО БОЛОН ТАМИРЧИН,
ДАСГАЛЖУУЛАГЧИД ТАВИГДАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

2.1. Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийн сонгон шалгаруулалтад дараах шалгуур үзүүлэлтэд нийцсэн спортын холбоо оролцоно:

2.1.1. олон улсын спортын холбоогоор хүлээн зөвшөөрөгдсөн байх;

2.1.2. тухайн спортын төрлөөр олимп, паралимпийн наадам, тивийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, тивийн аварга шалгаруулах тэмцээнд сүүлийн гурван жил медальт болон шагналт байрт шалгарсан байх;

2.1.3. спортын холбооны төсвийн зарцуулалт шилэн байх;

2.1.4. тухайн спортын холбоо нь Ажлын албатай байх.

2.1.5. тухайн спортын төрлөөр үйл ажиллагаа явуулдаг спортын холбооны ерөнхийлөгч, ерөнхий нарийн бичгийн дарга, ажлын албаны ажилтан нь үндэсний шигшээ багийн дасгалжуулагчийн ажил хавсран гүйцэтгэдэггүй байх;

2.1.6. спортын холбоо бүр тухайн жилийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын дүнгийн дөрөвний нэгтэй тэнцэх хэмжээний эрсдэлийн сантай байх;

2.1.7. Авлигын эсрэг хуулийн 4.1.5-д заасны дагуу спортын холбоог төлөөлөх эрх бүхий удирдах албан тушаалтан болон санхүүгийн ажилтан “Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23.3-т заасан хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулалтын мэдүүлэг /ХАСХОМ/ гаргасан байх;

2.1.8. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу спортын холбооны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, үндэсний шигшээ дасгалжуулагч нар хоорондоо хамаарал бүхий этгээд биш байх;

2.1.9. улсын бүртгэлийн гэрчилгээ, шинэчилсэн бүртгэлд хамрагдсан байх;

2.1.10.харьяалах нийслэлийн дүүргийн татварын албанд бүртгэлтэй байх;

2.1.10.арилжааны банканд улсын төсвийн санхүүжилтийг хүлээн авч, зарцуулах данс нээлгэсэн байх, мэргэжлийн нягтлан бодогчтой байх;

2.1.12.холбооны дүрмийн дагуу техникийн, ёс зүйн, шүүгч, дасгалжуулагчийн зөвлөлтэй байх /Удирдах зөвлөлөөр баталгаажсан байх/;

2.1.13.санхүүгийн үйл ажиллагаа, тайланд жил бүр аудитын үнэлгээ хийлгэдэг байх;

2.1.14.татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын албанд өргүй байх;

2.1.15.биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай өмнө нь гэрээ байгуулсан бол хэрэгжилт, санхүүжилттэй холбоотой тайлан, баримтуудыг гаргаж өгсөн байх;

2.1.16.үндэсний шигшээ багийн тамирчин, дасгалжуулагчдын ур чадвар, дотоодын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор насанд хүрэгчид, залуучууд, өсвөр үеийн насны ангилалд тэмцээн зохион байгуулдаг байх;

2.1.17.орон тооны болон гэрээт эмч, массажисттай байх.

2.2.Үндэсний шигшээ багийн дасгалжуулагч нь дараах шалгуур үзүүлэлт хангасан этгээд байна:

2.2.1.биеийн тамир, спортын чиглэлээр их, дээд сургууль төгссөн, бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх;

2.2.2.Биеийн тамир, спортын тухай хуулийн 24.1-д заасан эсвэл олон улсын спортын холбооноос спортын сургалт-дасгалжуулалтыг эрх авсан байх;

2.2.3.хувийн ёс зүй, манлайлал, мэргэжлийн ур чадвар, өндөр зэрэглэлийн тамирчидтай ажилласан ажлын туршлагатай, мэргэшсэн байх;

2.2.4.тухайн дасгалжуулагчийн бэлтгэсэн тамирчдын гаргасан амжилт өсөлттэй байх;

2.2.5.олон улсын болон үндэсний спортын холбооны дүрэмд заасны дагуу дасгалжуулагчид тавигдсан холбогдох шаардлагыг хангасан байх;

2.2.6.дэлхийн болон үндэсний допингийн эсрэг дүрэм, стандарт, хориотой бодис, аргын талаар мэдлэгтэй байх;

2.2.7.хөдөлмөрийн насны иргэн байх;

2.2.8.холбогдох олон улсын гэрээ, конвенц, хууль, эрх зүйн зохих мэдлэгтэй байх;

2.2.9.сүүлийн 2 жилд олон улсын болон үндэсний холбооны дүрмийн дагуу ёс зүй, сахилгын шийтгэл хүлээж байгаагүй, харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай байх;

2.2.10.интернэтийн орчинд ажиллах, компьютерын өргөн хэрэглээний программын дундаас дээш шатны мэдлэгтэй байх (шалгалтын дүн);

2.2.11.гадаад хэлний зохих түвшний мэдлэг, ярианы чадвартай байх (шалгалтын дүн);

2.2.12.спортын шинжлэх ухааны онол, арга зүйн мэдлэгтэй, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний сорил, судалгааны үр дүнд анализ хийх, сургалт-дасгалжуулалтын төлөвлөлт, төлөвлөгөөнд тусган ашиглах, өрсөлдөгчийн судалгаа хийх өндөр чадвартай байх (шалгалтын дүн);

2.2.13. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан квотын дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн дасгалжуулагч дотроос үндэсний шигшээ багийн ахлах дасгалжуулагчийг сонгох.

2.3.Үндэсний шигшээ багийн тамирчин нь дараах шалгуур үзүүлэлт хангасан этгээд байна:

2.3.1.спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн эмнэлгийн үзлэг, ажиллах чадвар, сэтгэл зүйн сорилд орж, өндөр зэрэглэлийн тамирчны тогтоосон нормативыг биелүүлсэн байх;

2.3.2.өндөр амжилт гаргах магадлалтай, ур чадвартай, бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүй, бэлтгэлжилтийн түвшинд тавигдах шалгуурт нийцэх эсэх талаар Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн сорил болон эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлтээр амжилт гаргах боломжтой байх;

2.3.3.сахилга бат, ёс зүйтэй, харилцааны соёлтой, хариуцлага хүлээх чадвартай байх;

2.3.4.тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, наадамд медальт болон шагналт байранд шалгарсан байх (сүүлийн 3 жилд);

2.3.5.тухайн спортын төрлөөр өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн, улсын хэмжээний спортын наадамд медальт байранд шалгарсан байх (сүүлийн 3 жилд);

2.3.6.биеийн тамир, спортын тухай хууль тогтоомж, олон улсын болон үндэсний спортын холбооны дүрэм, дэлхийн болон үндэсний допингийн эсрэг дүрэм, стандарт, хориотой эм бэлдмэл, арга, эмчилгээний талаар мэдлэг, мэдээлэлтэй байх.

---о0о---

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын
сайдын 2025 оны дугээр сарын
-ны өдрийн дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
СПОРТЫН ХОЛБООГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ATA 129316594204 9824070548

- Дарга: Биеийн тамир, спортын улсын хорооны дарга.
- Гишүүд: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга;
Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого
төлөвлөлтийн газрын дарга;
Биеийн тамир, спортын улсын хорооны харьяа
Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн
захирал;
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны
Стратеги бодлого төлөвлөлтийн газрын Биеийн тамир,
спортын бодлого, төлөвлөлт, тайлагналт, судалгаа
хариуцсан шинжээч;
Монголын үндэсний олимпын хорооны төлөөлөл;
Монголын үндэсний паралимпын хорооны төлөөлөл.
- Нарийн бичгийн дарга: Биеийн тамир, спортын улсын хорооны Үндэсний
шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтсийн
дарга.

---00---